

**Монголын орчин үеийн уран зохиолд социалист
реализмын арга үүсч хөгжихөд М.Горькийн
захидал чухал ач холбогдолтой нь
үнэн үү?**

*Д.Галбаатар (Токиогийн гадаад
судлалын их сургууль)*

Монголын орчин үеийн уран зохиолын судлалд бодит байдлаас гажсан олон дүгнэлт, үзэл баримтлал байдгийн нэг нь Эрдэнэбатхаанд М.Горькийгоос ирүүлсэн хувийн хариу захидлын утга агуулга, зарим нэр томъёог гуйвуулан М.Горькийн захидал-зөвлөлгөөгөөр монголын уран зохиолд социалист реализмын арга эхлэлээ тавьж цааш хөгжсөн мэтээр тайлбарлаж ирсэн нь нэн мөчид гоомой дүгнэлт бололтой.

1923 онд хуралдсан МАХН-ын II их хурал дэлхийн болон Орос-Зөвлөлтийн сонгодог уран зохиолоос орчуулах нь чухал /13,4/ гэж зааснаар "утга зохиолыг орчуулах ажлыг чухам юунаас эхлэх вэ" гэдэг тулгамдсан асуудал монголын сэхээтнүүдийн өмнө тулгарсан байна.

Чухам үүнээс гарах арга замыг эрж сүвэгчилж байх үед М.Горькийд огт өөр асуудлын талаар хувийн захидал бичиж суусан гэгээрлийн сайд гэнэт санасан бололтой /эсвэл хэн нэг зохиолч дэргэд нь байсан Д.Г/ захидлынхаа төгсгөлд ямар зохиол орчуулбал зүгээр болох тухай цөөн үгтэй өгүүлбэр бичиж дайгаад нэгэн хариу захидал авчээ.

Тухайн үедээ хэн ч хайхраагүй М.Горькийн цөөн үгтэй энэ захидлын зарим нэг үг, өгүүлбэр хожим хойно их үнэ цэнэтэй сургаал, Монголын уран зохиолын хөгжлийн мөрийн хөтөлбөр болчихно чинээ хэн ч бодоогүй нь 10, 11 жилийн дараагаар дахин холбоо барих гэж оролдсон Эрдэнэбатхаан болон монголын шинэ залуу уран зохиолчдоос бичсэн хоёр янзын захидлын агуулгаас харагддаг юм.

Гэсэн хэдий ч М.Горькийн захидлын агуулга, түүнд хэрэглэсэн нэр томъёо, бичигдсэн түүхэн нөхцөл байдал, он цагийг нарийн судлахгүйгээр "Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. 1921-

1965" /1968/-д "... энэ үг /М.Горькийн зөвлөлгөө. Д.Г/ зөвхөн орчуулгын зохиолын гол чиглэлийг зааж өгсөн төдий биш, шинээр цогцлон бүтээгдэж байсан хувьсгалт утга зохиолын үндсэн агуулгыг тодорхойлон заасан юм." /1.33/, "энэ замыг пролетарийн их зохиолч М.Горький зааж өгсөн юм" /1.32/ гэх ба "Монголын орчин үеийн уран зохиолын түүх /1921-1980/" гурван боть бүтээлд "Монгол-Зөвлөлтийн уран зохиолын харилцаа, соёл иргэншлийн түүхэнд коо шинэ зүйл байлаа.

Энэ харилцааны эх үндэс социалист реализмын уран зохиолыг үндэслэгч үлэмжийн их Горькийтой холбоотой юм. М.Горький социалист реализмын онолч, агуу их уран бүтээлчийн аль ч талаараа монголын хувьсгалын уран бүтээлчдийн замыг зааж өгсөн байна." /2.14/ зэргээр хуудуутай үгээр сүржин дүгнэлт хийсэн байх буюу судлаач Ц.Хасбаатар "Монголын хувьсгалт зохиолчид пролетарийн их зохиолч М.Горькийтой захидал бичгээр харилцаж түүний мэргэн зөвлөлгөөг сонсож, шинэ амьдралын төлөө идэвхтэй тэмцэх зарчмыг уран бүтээлдээ баримталсан нь манай утга зохиолыг реализмын замаар хөгжүүлэхэд үлэмж ач холбогдолтой болсон юм." /3.4/, П.Хорлоо "Горький бол оросын сонгодог утга зохиолын их уламжлалыг залгамжлан үргэлжлүүлэгч, социалист утга зохиолыг үүсгэгч юм." /4.147/ гээд "манай ард түмэн ба түүний сэхээтнүүд өөрийн үндэсний хувьсгалт соёлыг хөгжүүлэхийн тулд ... их бичгийн хүн М.Горькийн зүг ах дүүгийн ёсоор хандсан нь манай ард түмний соёл, урлаг өв тэгш мандах явдлын уг сурвалж нь болов." /4.148/ зэрэг үгээ олж ядсан, хоорондоо хамааралгүй /зөвхөн дам байж болох. Д.Г/ зүйлсийг зориудаар холбоотой болгож бичсэн зүйлс Л.Түдэв, Д.Цэнд, С.Лувсанвандан, Ц.Мөнх, Г.Ринченсамбуу болон залгамж үеийн залуу эрдэмтдийн бүтээлээс олон арвыг иш татаж болох юм.

Энэ мэтээр М.Горькийн хувийн захидлыг монголын шинэ үеийн уран зохиол, түүний уран бүтээлийн аргын үндсийг тавьсан чухал баримт бичиг гэж үзэх зохиомол номлол өргөн дэлгэрчээ. Үнэндээ М.Горький "социалист реализмтэй нэр холбоотой ч чухам ямархуу хэв загвар, зарчим зүйтэй арга болохыг үзэх завдалгүй ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн билээ. Харин монголын социалист реализмын уран зохиолын түүх 1948 онд хуралдсан МЗЭ-ийн анхдугаар их хурлаар "хувьсгалт реализмын метод" гэж албан ёсоор зарласнаар бодит зүйл болж эхэлсэн юм.

Оросын эрдэмтэн Л.К.Герасимович /5.223-224/, Буриадын эрдэмтэн В.Найдаков /6.17/ Монголын эрдэмтэн Ц.Хасбаатар /7.43,68/ нар М.Горькийн захидлын ач холбогдлыг бусдын адил хүлээн зөвшөөрдөг боловч 1920-30-аад оны монголын уран зохиолд социалист реализмын арга байсан гэж үзэх нь учир дутагдалтай гээд харин ч тэр үед натурализм, символизм, сентиментализм, романтизм болон бусад аргын нөлөө хүчтэй байсныг дурьдан 1940-50-иад оноос реализм эрчимжиж тэхдээ дорнын хэв төрхийг хадгалсан уламжлалт монгол реалист арга барил бус харин европ хэв шинжийн реализм буюу социалист реализм хөгжиж ирснийг ажигласан нь сайшаалтай хэрэг юм.

1930-аад оны дундуур Оросын уран сайхны практикт анх томъёологдоод дэлхийн дайны дараа хэв төрхөө олсон социалист реализмын аргыг М.Горькийн 1925 оны захидалтай холбох нь ойлгомжгүй зүйл юм. Баримтуудыг харьцуулж үзвэл нийгмийн нэг байгуулалтад

"дэвшин" орсон "ахан дүү"-гийн ган бат найрамдал нь уран зохиолын салбарт ч эртнээс эхэлжээ гэж харуулахын тулд манай хожуу үеийн судлаачдаас зохиосон шинэ цагийн үлгэр болохыг дараах захидлууд баталдаг юм. Харин энэхүү өгүүлэлд түүхэн ёсоор бий болсон Монгол, Зөвлөлтийн /хуучин/ уран зохиолын гүн зузаан холбоо, Орос Монголын ард түмний андын уламжлалт барилдлагыг үгүйсгэх, Монголын уран зохиолд социалист реализм байгаагүй гэж няцаах санаа огт бариагүйг хэлэх нь зүйтэй юм.

Уран бүтээлийн аливаа арга үүсч хөгжих, хувьсан өөрчлөгдөх, халж солигдох, салбарлан задрах үйл явц зөвхөн урлаг, уран зохиол төдийгүй нийгэм, түүх, улс төрийн амьдрал дахь өөрчлөлт, тухайн үндэстний зан заншил, ертөнцийг үзэх итгэл үнэмшилтэй /үзэл/ холбоотой нарийн нийлмэл үйл явц мөн. Орос, Зүүн Европ, Төв болон Зүүн, улмаар умард Ази, Америкийн /Куба/ нэлээд орон социалист реализмыг бэрхшээл багатай өөр өөрийн онцлогт нийцүүлэн авсан нь суурин соёл иргэншлийн онцлогт зохицсон аман хэлбэр давамгайлсан, холимог арга бүхий аман ба бичгийн уран зохиолын уламжлалаас социалист реализмд шилжсэн нь өвөрмөц, түүхэн урт удаан замыг туулахад хүрсэн юм.

Социалист реализм Октябрийн хувьсгалын үзэл санааны дор "социализм байгуулалтын жилүүдэд" уг замыг сонгосон олон орны урлаг, уран зохиолын арга болж боловсорсон философи-гоо зүй- урлагийн бүхэл бүтэн систем мөн. Харин бие даасан чиглэл болтлоо үндэстэн бүрийн уран зохиолд өөр өөрийн өвөрмөц түүхэн түвэгтэй, зөрчилт замыг туулсан билээ. Ийм учраас монголын урлаг, уран зохиол дахь социалист реализмын аргын хөгжлийн асуудлыг бодитойгоор дүгнэхэд Горькийн захидлын учир холбогдлыг зөв тогтоох нь их ач холбогдолтой юм. Ийм учраас дараах баримтуудад тулгуурлан өөрийн бодол санааг хэлэхийг хүссэн билээ.

Г.Жамсранжав "Ванчинбалын Иннжиннашийн романуудын тухай" өгүүлэлдээ "Хөх судар" романаар жишээ болгон монголчууд реалист чиглэл бүхий уран зохиолтой байсан гэж тэмдэглэснийг Ц.Хасбаатар үгүйсгээд XIX зууны үед реалист аргыг дахин эзэмших санаачлага гаргаад яах юм бэ гэж ёгтлон шүүмжилжээ. Ямар ч атугай реализм монголчуудын хувьд их эртний сурвалжтай, уран бүтээлийн буурьтай арга гэдгийг, мөн "социалист реализм" хүн төрөлхтний тэр дундаа монголчуудын уран сайхны сэтгэлгээний практикийг баяжуулан, үр ашигтай олон шинэ зүйл нэвтрүүлснийг ч үгүйсгэх аргагүй юм. Социализм байгуулагчид төдийгүй дэлхийн бүх улс үндэстэн өөрийн аман ба бичгийн уран зохиолын реалист хүчирхэг уг сурвалжтай. Дэлхий ертөнц дээр социализм, коммунизмын үзэл санаа оршин тогтнож, социалист, коммунист намууд үйл ажиллагаагаа явуулан Маркс, Лениний сургаал номлолыг судалж ахуй цагт социалист реализмын арга, онол, уран бүтээлийн практикт байсаар байх нь ч тодорхой зүйл юм.

Социалист реализм жинхэнэ утгаараа бий болсон түүхэн үе буюу 1940-50-аад онд Монголын шинэ уран зохиолын хувьсгалт үзэл санааны уламжлалд тулгуурлан урьд өмнгө байгаагүй Оросын шинэ социалист урлагийн уран бүтээлийн арга, зарчмууд монгол туурвил зүйд нэвтрэн

орж ирснийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй юм. Гагцхүү 1920-30-аад оны үеийн уран зохиолд түүнийг хамаатуулах үндэслэл маш бага юм.

Эрдэнэбатхаан 1925, 1935 онд М.Горькийд тус тус нэг захидал, 1936 онд залуу зохиолч Ши.Аюуш, Содномдорж, Өлзий-Очир, Жаргалсайхан, Д.Сэнгээ, Сэнгэдорж, Самдан, Санжид /Улс төрийн уран сайхны зөвлөлийн дарга Аюуш, Уран зохиолчдын төв товчооны дарга Сэнгэдорж/ нарын бичсэн "БНМАУ-ын залуу шинэ уран зохиолчдоос ... 26 /1936/ дугаар он 4 сарын хорингоо" гэж эхэлсэн 9 хуудас гар бичмэл захидлыг оросоор орчуулж машиндсан 4 хуудас дагалдуулсан", "С.Буяннэмэхийн нэрийг хар бэхээр дарсан" /8,4/ /дарсан хүн нь Ши.Аюуш бололтой. Л.Т/ бүгд 3 захидал одоо М.Горькийн гэр музейн хөмрөгт хадгалагдаж байна. Эл гурван захидлаас Эрдэнэбатхааны 1925 оны анхны захидалд хариу ирсэн түүхтэй.

М.Горькийд Эрдэнэбатхаанаас бичсэн захидалд өөрийн ард түмний соёл, шинжлэх ухаан, боловсрол хэрхэн хөгжиж ирсэн ба одоогийн байдал, түүний дотроос монголын шинжлэх ухаанд боловсролын асуудал нь нүүдэлчин ахуй хийгээд шарын шашны зан үйл, сургалтын мөн чанартай гүнзгий холбоотойг дурдан тайлбарлаж, хийж буй улс төр, нийгмийн шинэчлэл, ЗСБНХУ-ын бүрэлдэхүүнд буй Буриад монголчуудын хэлний асуудлаар хувийн бодлоо дэлгэрэнгүй бичээд баруун зүгийн орнуудад соёлын үнэт зүйлсийг дахин цэгнэж буй энэ ХХ зууны дорно дахины ард түмний сэргэн мандаж байгаа нь ерөөсөө их сонирхолтой хэрэг юм. Одоохондоо сэргэлт зөвхөн эхэлж байх тул урагшаа хир зэрэг хурдан хөгжих, үүнд юу хэрэгтэй болох нь бидний хувьд аргазүйн асуудал болоод байна.", "монголд соёлын салбарт юу хийгдэж байгааг тодорхой мэдэхийг хүсвэл дуртайяа бичнэ"/9.13/ гэжээ.

Энд "арга зүй" гэдэг үгийг үндэсний соёл, боловсролоо хөгжүүлэхэд юу хийвэл зохистой вэ гэсэн ерөнхий утгаар хэрэглэжээ. Захидал бичигч энэ хэсэгтээ бид ийм аргазүйг барьж байна, барьвал ямар вэ гэж асуусангүй, харин "хүсвэл дуртай бичнэ" гэснээс үзэхэд тэр үед уран зохиол, урлагт аргын тухай асуудал төдий л хөндөгдөөгүй байсныг харуулна.

Захидлын төгсгөлд сайн сайхны ерөөл талбиж, өөрийн нэр хаягийг тодорхой бичсэний дараа дор нь "Жич:- хэмээгээд Оросын уран зохиолоос монгол хэлээр орчуулах шаардлагатай ба энэ ажилд /орчуулга Д.Г/ ямар зарчим баримтлах, юунаас яаж эхлэх талаар "заавар" онц сонирхолтой, үнэтэй юм гээд "Бидний хүч хязгаартай, шууд их зүйлийг хамран авах бололцоогүй тул олон юмнаас монгол ухаанд ойр дотно, илүү тохиромжтой зүйлийг сонгон авах хэрэгтэй болох л байх даа" /мөн тэнд/ хэмээн гадаад хэлнээс орчуулах зохиолыг сонгох, энэ ажлыг гүйцэтгэхэд заавар зөвлөлгөө өгөөч гэснээс өөр уран зохиолын хөгжил, онол бодрол, уран бүтээлийн аргын тухай нэг ч үг өгүүлбэр бичээгүй байна.

М.Горький хариу захидалдаа монголын сэхээтнүүдийг ахмад туршлагатай уран бүтээлчийн хувьд хүн хүчний хувьд "их биш" гэдэг та нарыг зовоох ёсгүй. "Тоо биш чанар чухал шүү. Хэдэн арван шийдэмгий хүний хүчээр Оросын үй түмэн ноомой тариачид шинэ амьдралд дэвшиж

буйг та нар бэлхнээ мэдэх биз", Оросын уран зохиолыг монгол хэлэнд орчуулахдаа ямар зарчмыг баримтлах вэ гэсэн асуултанд "би яв цаваар хариулж чадна гэж үү дээ? /Горький Оросын уран зохиолоос илэрхий булзаж европ руу анхаарлыг хандуулсан нь ихээхэн учир холбогдолтой юм. Учир нь Оросын уран зохиолд шашныг болон хуучныг баримтлагчид, анархистууд, үндсэрхэх үзэлтний бүлэглэлүүд тэрчлэн модернизмын олон урсгал дэлгэрч, гүн гүнзгий хямрал болж байсан бөгөөд түүний ирээдүй тодорхойгүй байв. Д.Г/ Гэвч монголын тухай миний уншсан номыг баримталж, монгол хүний сэтгэлийн тухай миний бодоход таны ард түмэнд идэвхтэй зарчмын номлол, ялангуяа тус бололтой" /9,7/ гэж хариулжээ.

Үүнээс "Идэвхтэй зарчим" гэдэг үгийг манай судлаачид таслан авч эхлээд "реализм", дараа нь "социалист реализм" гэжухаарсан бөгөөд одоо ч тэгж ойлгож байна. Миний бодлоор энэ өгүүлбэрийг өмнөх ба дараах хэсэгтэй холбож үзвэл ямар нэг идэвхтэй зарчим гэсэн хэмээх онол, аргын тухай Горький хэлсэнгүй. Тэр "Энэ асуултанд ... яв цаваар би хариулж чадна гэж үү дээ".

Монголын тухай уншсан номыг баримтлаж, монгол хүний сэтгэлийг бодоход "идэвхтэй зарчим" /орчуулгын тухайд шүү. Д.Г/ тусгай бололтой" гэж бичсэн нь дараагийн мөрний "Бүх олон ястанд хүртээх олон сайхан юм гэж Европт байдаг болбаас тэр цөм аж амьдралаа идэвхтэй зохиодгийн ачаар бүтжээ.", "Хүсэл бол зовлонгийн үүсэл гэж бурхан номложээ. Европ бол чухамхүү нэгэнт олдсон зүйлээс ямагт дээр сайныг олохын тулд тохиолдох зовлонгоос огт айдаггүй байсан учраас шинжлэл, урлаг, техникийн талаар дэлхий дахины бусад улсаас ихэд урагш дэвшжээ. Европ бол өөрийн ард түмний шударга чөлөөг эрмэлзэх сэтгэлийг өрнүүлж чадсан юм.

Гагц үүний тул түүний олон гэм нүглийг бид уучилж болно" /мөн тэнд/ гэж бичсэнтэй маш нарийн логик холбоотой бөгөөд Эрдэнэбатхааны захидалдаа бичсэн "монголд боловсрол дэлгэрүүлэх явдал ... байгалийн нөхцлөөс үүдэж монголчууд өнөөдөр хүртэл нүүдэлчин хэвээр, мөн цаашдаа ч удтал байх төлөвтэйгээс их нарийн түвэгтэй болж байгаа юмаа.

Одоо хүртэл сургуулиуд Буддын шашны гарт байгаа бөгөөд тэдгээр нь орон даяар цацагдаад нүүдэлчдийн суурьшил соёлын төв болсоор байгаа буддын олон тооны хүрээ хийдүүдэд төвлөрчээ. /9,9/ зэрэг захидлын дүгнэлт ба бурханы сургууль, нүүдлийн аж ахуй, соёлын ерөнхий хандлага, ноомой хүлцэнгүй хоцрогдсон байдлыг М.Горький таамаглан ойлгож ерөнхийдөө европ зүгийн суурьшмал соёл иргэншил, амьдралын төлөө /сайн сайхан/ тэмцэгч чанарыг барьж "идэвхтэй зарчим, ухааны шургуу дүрийг илт үзүүлсэн", "ноомой чөлөөг хүсэх биш, жинхэнэ эрх чөлөөг хүссэн зүйлийг шилж орчуулбаас зохих болов уу" гэсэн төв ухаалаг зөвлөлгөө өгч "Пастер, Парадей юмуу Франклин, Гарибальд шиг хүмүүсийн намтар их ашигтай... Харин уран зохиолоос эрх чөлөө, шударга үзлийг удирдлага болгодог /хувьсгалыг талархагчийн Д.Г/ хүмүүсийн баатарлаг үйлсийг хамгийн хурц тод харуулсныг нь сонгож авах хэрэгтэй. Энэ талаар хамгийн илүү тохиромжтой номыг одоогоор нэрлэхэд хэцүү байна." /9,8/ гэснээс үзвэл уран зохиол бичих

арга барилын тухай, уран зохиол ямар байх талаар тэр тусмаа "социалист реализм"-ын тухайд огт дурссангүй /дурсах ч зүйл байгаагүй. Д.Г/ зөвхөн европоос ямар зохиолыг монгол хэлэнд орчуулбал зүгээр болох тухай өөрийн санааг бичжээ.

Түүгээр ч зогсохгүй капитализм ид цэцэглэж байсан европын уран зохиол, урлагийн мөн чанар, хувьсгалт шинэ уран зохиолын үлгэр туршлагын талаар ч огт дурсаагүйг үзэхэд социалист реализмын онолын асуудал ч социалист реализмыг "үндэслэгч"-ийн санаанд орж ирээгүй байсны илрэл бөгөөд эртний соёлт Италийн Соррентод сууж жинхэнэ чөлөөт, сонгодог урлаг, элит уран бүтээлийн мөн чанарыг ухааран мэдэрч асан М.Горькийд европын уран зохиол дахь шинэ эрэл хайгуул, Орос дахь хувьсгал ба түүний эсрэг үзэл санаанд нэгдэн гарч ирсэн 1920-иод оны Оросын уран зохиолын олон урсгал, бүлэглэлийн хувь заяа, зам мөр тодорхой болоогүй, пролетарийн шинэ соёл бүрэлдэн төлөвшиж чадаагүй байсантай, мөн М.Горькийн үзэл санаа, улс төрийн үйл ажиллагаанд гарсан үзэл санааны зөрчилт тал, Монголд ардын хувьсгал ялсан зэрэг нь энэ захидалд шууд хариу өгөхөд хэцүү /эрт/ байсныг үгүйсгэх аргагүй юм. Тэр ямар нэг арга Оросын уран зохиол, хувьсгал, реализмын талаар зөвлөх бодол өвөрлөөгүй, тийм үг, өгүүлбэр, санаа ч захидалд байхгүй байна. Тийм боломж бүрдсэн байсан уу гэвэл байсан.

Үүнээс үзэхэд М.Горькийн захидал ба түүний "идэвхтэй нэр томъёог монголын шинэ үеийн уран зохиолын аргын хөгжлийн түүхтэй хольж хутгах нь буруу юм. Ийнхүү "М.Горькийн чухал зөвлөлгөө, мэргэн сургаал, үзэл баримтлал, мөн социалист реализмын арга монголын уран зохиолд хөгжих онол, арга зүйн үндэс болсон гэдэг дүгнэлт монголын улс төржсөн уран зохиол судлалын нэлээд хожуу үед гаргаж ирсэн монгол судлаачдын өөрсдийн зохиосон "онол" мөн.

Энэ нь монголын зохиолч сэхээтнүүд Зөвлөлтийн /хуучин/ уран зохиол, пролетарийн их зохиолчоос арга, туршлага судлахыг хичэнгүйлэн эрмэлзэж байсныг үгүйсгэж байгаа хэрэг огтхон ч биш юм. Эрдэнэбатхаанаас 10 жилийн дараа М.Горькийд бичсэн хоёрдугаар захидалд /1936/ ч уран зохиолын талаар огт дурсаагүй, харин хуучин танилын ёсоор өөрийн бүтээл туурвил, үйл ажиллагааны талаар танилцуулж, М.Горькийн ирүүлсэн хариу захидалд буй "санаа, зааврыг биелүүлэхийг эрмэлзэж... ЗСБНХУ-д бүтээгдэж түүгээр дамжин дэлхийд нөлөөлж байгаа яруу сайхан шинэ түүхийн хуудсанд багтахыг" /пролетарийн хувьсгалт соёл урлаг гэсэн утгаар бололтой. Д.Г/ хүссэнээ илтгэсэн атлаа ганцхан жилийн өмнө, шинэ тутам тунхагласан "социалист реализм"-ын онолыг нь ч "санаачлагч" их зохиолчоос асууж сонирхоогүй байна. Үүнээс үзвэл Эрдэнэбатхааны хоёр захидлын агуулга уран зохиолын арга маягийн тухай бус харин шинэ Монголын соёл боловсрол, шинжлэх ухааны чиглэлд туршлага, зөвлөлгөө авахыг хүсч байсан нь тодорхой болж байна.

Харин залуу зохиолчдын 1936 онд М.Горькийд илгээсэн захидлын агуулга нэлээд өөр юм. Энэ үед /1934/ Зөвлөлтийн /хуучин/ Бүх Холбоотын Зохиолчдын анхдугаар их хурлаар "Социалист реализм"-ын арга онолын хувьд томъёологдон тулгуур зарчмуудаа тодорхойлоод байсан цаг билээ.

Уг захидалд "шинэ монголын ард түмэн ба уран зохиолчдын сонорт хэдүйн алдаршин сонсогдож, мөрдөгдсөөр авч ... Тан лугаа хувьсгалын ёсны ажлын холбоо байгуулж ... Таны ... гүн их заавар сануулгыг хүлээсэнгүйгээр /Эрдэнэбатхаанд ирсэн захидлыг дурдаагүй, мөн цаг хугацааг 15 жил гэсэн нь 1921 оноос хойш гэсэн үг юм. Үүнээс үзвэл монгол зохиолчид Эрдэнэбатхаанд ирүүлсэн хувийн захидлын талаар мэддэггүй байжээ. Д.Г/ 15 жил болсон нь харамсаж үл гэмшилтэй дутагдал даруй мөн бөгөөд хэдийнээс эхлэн пролетарийн их зохиолч Тан лугаа шинэ монголын залуу зохиолчдоос харилцаж удирдлага зааврыг хүлээсэн ахул Монголын уран зохиолчид нь одоогийн байгаа байдлаас ихээхэн дээд хэмжээнд хүрээд байж болох асан" /9.17-18/ гэж бичсэнийг үзэхэд М.Горькийн 1925 оны хариу захидалд уран бүтээлийн арга болон реализмын тухай санаа байгаагүй, Монголын зохиолчид онол, аргазүйн хувьд реализмыг үндсэн утгаар нь ойлгож түүнийг удирдамж болгож байсан зүйл үгүйг давхар нотлодог юм. Ийнхүү лавтайгаар 1936 оныг хүртэл монголын уран зохиолд социалист реализм байтугай манай судлаачдын маргасаар байгаа "хувьсгалт реализм"-ын тухай асуудлыг ч ярих боломжгүй юм. Харин энэ үед ЗХУКН /большевик/, МАХН-ын их бүгд хурлын тогтоол шийдвэрт, хувьсгалт урлаг, уран зохиолыг хөгжүүлэх талаар улс төр, үзэл суртлын тодорхой зорилт, заалтуудыг ерөнхий чиглэл болгон зохиолчдын өмнө тавьж байсныг үгүйсгэж болохгүй.

Монголын залуу зохиолчид ч арга барилаа чөлөөтэй сонгож, янз бүрийн эрэл туршилт хийсээр боловч шилдэг сайн аргыг олохгүй байгаагаа "монголын уран зохиолчид нь залуу идэр ... дадлага, сурлага, мэргэжлээр туйлын дутмаг учир гагцхүү өөрийн оргилсон идэвх авьяас хүчинд дулдуйдаж хоосон бусын төдий янз бүрийн арга маяг буюу чиглэлтэйгээр зохиох, найруулах явдлыг оролдсоор авч алив зүйлээр тулгуур мөхөстөж тодорхой шулуун аргыг олохгүй явдал олонтаа баймой. /мөн тэнд/ гэж захидалдаа бичиж байжээ.

Үүнээс үзэхэд социалист реализмын аргын төлөвшилтийн тухай 1921-48 оныг хүртэл дангаар нь ярих боломжгүй гэсэн бидний үзэл баримтлал улам итгэлтэй болж байна. Уран бүтээлийн дадлага, туршлага дутмаг байдлаа "толгой холбохыг чухалчлан үздэг", "Үндэсний хэлний талаар онц баялаг бус"¹, Тол төлөв байгалийн зүйлийг найруулах", "Бас хоосон чанарын үгсүүдийг /дүр дүрслэлд. Д.Г/ хэрэглэх /буг, чөтгөр, мангас, махчин/, зарим зохиолчид Хятадын үлгэр түүхийн хуучин арга, маягийг хэрэглэх, түүний ёс журмыг ягштал баримтлах" /мөн тэнд/ явдал цөөнгүй гэж илэрхийлснийг харахад 1940-өөд оныг хүртэл /удалгүй халх голын болон дэлхийн 2-р дайн эхэлж энэ зүгт тавих анхаарал суларчээ. Д.Г/ зөвхөн шинэ маягийн реалист уран бүтээлийн аргыг зохиолч бүр баримтлан дэмжиж байсан гэх үндэсгүй бөгөөд харин ч бодочлон бичих, хийсвэрлэн /хэлбэрдэх/ дүрслэх, болзолт ба болзолт бус, шинэ, хуучин аргуудыг чөлөөтэй ашиглан /гол төлөв холимог хэлбэрээр/ нэгэнт ялсан хувьсгалын үзэл санаа, сурталд зохиолынхоо агуулгыг нийцүүлэхийг зохиолчид эрмэлзэж, олон арга барилд зэрэгцэн хөгжиж, зохиолчид өнгөрсөн ба тухайн үеийнхээ туршлагадаа дулдуйдан ирээдүй рүү чиглэсэн уран бүтээлийн нэг туршилт, эрлээс нөгөөд шилжин шинэ уран зохиолын эхний хорин жилийн адармаа, түвэгтэй шилжилтийн үеийн уран зохиолын түүхийг бүтээжээ. /Энэ тухай эл

өгүүллийг бичигчийн "Монголын уран зохиолын аргын судалгаа" /10,138-159/ докторын зэрэг горилсон ганц сэдэвт зохиолын 3, 4-р бүлгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

1936 онд М.Горькийд захидал бичигчид "манай уран зохиолчдын ажил болбол 1927 ба 1928 оны үеэс эхлэж хөгжсөөр ирсэн боловч түүний түүх байдлаас үзвээс нэг хэдэн сар туйлын идэвхтэйгээр оргилон хөдөлж ажлыг явуулаад дараа нь мэдээ чимээгүй болж буурах мэтийн явдал үргэлжилсээр яваад энэ 35 оны дундуур хүрчээ" гээд "35 оны дундуураас хойш уран зохиолчдын ажлыг хөгжүүлэх талаар бага сага арга хэмжээ авах буюу тийнхүү хуучин арга журмаар нэг сэхэж, нэг буурах байдалд хүргүүлэхгүйн тулд улс төрийн уран сайхны зөвлөлөөс арга хэмжээ авч" /мөн тэнд/ эхлэсэн тухай өгүүлсэн нь нэг талаас 10 гаруй бүлгэм хот, хөдөө бий болж улмаар урьд өмнө ший жүжиг, цахилгаан сүүдрийн /кино/ урлаг гол анхаарлаа тавьж байсан тухайн үеийн нам, төрийн бодлого уран зохиол руу 1930-аад оны сүүлч үеэс ихээхэн анхаарч эхэлсэнийг, нөгөө талаас 1929 онд МАХН-ын ТХ-оос байгуулсан "Хувьсгалын уран зохиолч нарын бүлгэм", 1930 онд байгуулсан "МАРЛ", мөн ондоо "МАРЗ" болон өргөжиж 1932 оны эхээр "Хувьсгалын уран зохиол" хэмээх уран сайхны анхны сэтгүүл бий болж Лениний "Утга зохиолын хэрэг бол нийт пролетарийн хэргийн бүрэлдэхүүн хэсэг байх ёстой." /11,1/ үгийг уриа болгосноор цаашид уран зохиолын хэрэг улам бүр улс төр, үзэл суртлын ажлын хэрэгсэл шинжтэй болж намч, ангич шинж ялгаран, интернационалист үзэл санааны зарчим гүнзгийрч байсныг харуулдаг билээ.

Залуу зохиолчид М.Горькийгоос дараах зүйлийг хүсэмжилсэн юм. Үүнд шинэ монголын залуу уран зохиолчдын ажилдаа цаг ямагт тод томруун заавар удирдлага, ажлын арга маяг, үндсэн чиглэл, зорилго, бодлогыг өгөх зэргээр монголын ба холбоот улсын халуун харилцаа, тусламжийг өрнүүлж ... Холбоот улсын уран зохиолчдын холхи хамгааллын дор Монголын залуу зохиолчдыг тэтгэн хүмүүжүүлж монголын үндэсний засаг төрийн тусгаар тогтнох хийгээд үндэсний хувьсгалын дайсны суртлыг ялж дийлэх суут тусламжийг үзүүлэх болов уу?" хэмээн "эрхбиш хүлээн авч хүссэн зүйлийг хангаж нэн даруй хариу ирүүлэхийг хүсч хол амрыг эрж ёслогч..." /9.18-19/ гэсэн ажээ.

Үүнээс үзвэл тэд М.Горькийн "идэвхтэй зарчим"-ыг захидалдаа дурдаж ач холбогдол өгөөгүй, социалист реализмын талаас дурсаагүй /мэдэхгүй байжээ. Д.Г/ харин ч өөрсдөө та нараас суралцаж, арга маягаа зааж өгөөч гэсэн гуйлтын санаатай байгаа нь 1920-1930-аад оны уран зохиолыг дан ганц "реализмын" гэж дүгнэх нь эндүү ташаа болохыг, нөгөө талаас социалист реализмыг Оросууд биш, харин монголын зохиолчид өөрсдөө хүсэн хүлээж, нэхэн шаардаж байсан нь тодорхой байна. 1936 онд ийм түвшинд байсан Монгол-Оросын уран зохиолын харилцаа ганц нэг жилийн дотор гүнзгийрч, социалист реализм гэнэт ялан мандсан байж таарахгүй билээ.

Доктор Л.Түдэв уг захидалд "хуучны" төлөөлөгч С.Буяннэмэхийн нэрийг хасч дарсан шалтгааныг "энэ нь ялыүй зүйл" мэт боловч "тэр үед зохиолчдын байгууллагад үзэл бодлын зөрөлдөөн гарч, уран сайхны болон арга барилын эрэл хийцгээж, онолын чиг баримжаа тогтоох шаардлага байсан цаг, бас гучааад оны үед өрнөсөн хэлбичгийг

сайжруулах бодлогын маргаан мухардалд ороход тулж очоод байлаа" гээд "Зөвлөлт Орос улсад ч гэсэн байдал мөн тийм уур амьсгалтай байсан цаг аж. Юуны урьд уран зохиолын аргыг нэг мөр болгон тогтоохыг футуризм, модернизм, сентиментализм, романтизм гэхчлэн олон "изм" ярьж, дур дураараа болж байсан манант цаг үе нь шаарджээ." /8,6/ гэснээс үзвэл Оросын хувьсгалт шинэ уран зохиолын дотоод амьдралд болж байсан шуугиант үйл явдлууд тал нутгийн монголчуудад хүрч, залуу уран бүтээлчдэд "юм" бодогдуулжээ.

Тэд өөрсдийгөө "шинэ монголын залуу уран зохиолчид" гэж нэрлээд монголын уран зохиолд ямар нэг огцом шинэчлэл хийхийг "мөрөөдөж" явжээ. Нэгэн жишээг хэлэхэд зохиолч Ц.Цэдэнжав дурсамждаа С.Буяннэмэх, М.Ядамсүрэн, Жаргалсайхан, Ч.Дашням, Өлзий-Очир нартай илт дайсагналцан ахмад зохиолчоос Ши.Аюуш, залуу зохиолч Д.Сэнгээ, Хорлоо, С.Дашдэндэв... нартай нийлэн эсэргүүг илчлэн, хардаж сэрдэн /энэ үед монголын зохиолчдын байгууллага нэрээ ойр ойрхон сольж, удирдлагууд нь халаа сэлгээнд өртөж байсан нь зохиолчдын байгууллагын дотоод тэмцлийг харуулдаг юм. Д.Г/ хувьсгалын ёсны ажилллагааг өрнүүлж явсныг /15. №169/ зохиолч Д.Норов Шадавлингийн зусланд хамт гараад байхдаа тэмдэглэн авч саяхан нийтлүүлжээ.

Монголын зохиолчид энэ үед яах аргагүй арга зүй, онолын хувьд мухардаж, үзэл бодлын хагаралтай байсан бөгөөд Оросын уран зохиол дахь модернист бүлэглэлүүдийн эсрэг Сталины явуулсан хүчирхийлэлийн бодлого, монгол дахь үндэсний сэхээтэн-лам нар болон шинэ цагийн болоювсролтой зохиолчид, сэхээтнүүдийн эсрэг чиглэсэн их хэлмэгдүүлэлт нэгэнт нүүрлээд байсан 1930-аад оны сүүлч үе тул арга буюу Орост Сталины санаачлагаар Горькийн үндэслэсэн "социалист реализмын арга"-ыг даган баясахаас аргагүй байдалд тулж ирснийг гэрчилдэг юм. Орос болон европт боловсрол олж, тэндэхийн соёл, урлаг, уран зохиолтой танилцаж, янз үрийн арга найруулгыг өөрсдийн уран бүтээлд туршин хэрэглэж асан үндэсний сэхээтэн Д.Нацагдорж, С.Буяннэмэх, Ши.Аюуш, М.Ядамсүрэн зэрэг олон шилдэг уран бүтээлчдийг 1937 онд хөнөөж, эхлээд Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, дараа нь Д.Намдаг, Л.Цэнд-Очир зэрэг гол гол уран бүтээлчдийг шорон, гянданд суулгаснаар "социалист реализм" монголын шинэ залуу зохиолчдын уран бүтээлийн арга болон хөгжих дотоод таатай нөхцөл бүрэлдсэн байна.

Энэ нь 1930-аад оны сүүл үеэс монголын урлаг, уран зохиолд социалист реализм Оросын пролетарийн диктатурт төрийн улс төр, соёлын бодлогын хүчтэй түрэмгийлэл, дотоодын хэт зүүний зохиолчдын идэвхтэй зүтгэлийн үр дүнд монголд экспортчилогдож, дорно дахины сонгодог уламжлал дээр бус европ хэв шинжийн сэтгэлгээнд тулгуурласан шинэ арга цаашид дангаар ноёрхох нь тодорхой болсон байна.

Уран зохиолын хөгжлийн эхний 10 гаруй жилд МАХН хувьсгал, шинэ капиталист бус суртал, бодлого, ядуу дунд ангийн эрх ашиг, интернационалист намч ангич зарчмыг урлаг, уран зохиолд удаа дараа дэвшүүлэн ерөнхий чиглэл өгсөөр байсан боловч Зөвлөлтийн оролцоо.

Оросын уран зохиолын нөлөөллийн асуудал "Шонхорын дуун", "Салхич шувуун дуун" зэрэг цөөвтөр зохиолоос хэтрэхгүй байсан бол 1937 оны их хэлмэгдүүлэлт дэгдэж улмаар Халх голын дайн, Дэлхийн 2-р дайн, 1945 оны чөлөөлөх дайны хөлөөр уран зохиол, урлаг илт хувьсгалжиж, дайны дараа зөвлөлтийн цэргийн тусламжтай социализмын шинэ чиглэл тогтож урлаг, уран зохиол ч социалист реализмыг уран бүтээлийн практикт нэвтрүүлэх шаардлага бий болж, Зөвлөлтийн зааварчилгаа, оролцоо, онол шийдвэрлэх үүрэгтэй болжээ.

Ийнхүү Дэлхийн 2-р дайны дараа Октябрийн хувьсгал, түүний дараах Иргэний дайнаар нөхцөлдөн гарсан Оросын уран зохиолын олон урсгал, Монгол болон Чех, Герман, Унгар, Полвш, Румын зэрэг зүүн европ, БНАСАУ, Вьетнам, Куба зэрэг орны чөлөөт сэтгэлгээний баялаг уламжлал тасалдаж социалист үзэл суртал бүхий реализм руу эргэлт буцалтгүй оржээ. Энэ үеэс социалист реализм системийн хандлагатай болж жинхэнэ төрхөө олсон юм. Хэдийгээр монголын хувьсгалын дотоод хүчин зүйлс, нам засгийн бодлого үлэмж учир холбогдолтой ч 1948 онд хуралдсан Монголын зохиолчдын анхдугаар их хуралд ирүүлсэн Зөвлөлтийн /хуучин/ Зохиолчдын холбооны баярын бичигт М.Горькийн захидлын утгыг өөрчлөн "Та нар 23 жилийн өмнө утга зохиолоо байгуулж /монголын уран зохиолын хуучин сонгодог өвийг илт үгүйсгэсэн. Д.Г/ эхлэхдээ Горькийгоос зөвлөлгөө эрээд ... Оросын их зохиолчийн мэргэн зөвлөлгөөг хүлээж авсан юм. Горькийгоос ард түмний ашиг тус, түүний тэмцэлтэй гүн холбоотой утга зохиолыг байгуулах хэрэгтэй гэсэн гэрээсийг бат санаж мөрөөдсөөр ирлээ гэж Зохиолчдынхоо их хуралд та нар зориг бадран хэлж чадах болжээ". Зөвлөлтийн зохиолчдын холбооны даалгавраар : А.Фадеев, К.Симонов, Н.Тихонов" /9,21/ гэсэн социалист системийн эзэн гүрний ихэмсэг дүгнэлтийг хийсэн юм.

Давтан хэлэхэд М.Горький Монголын уран зохиолыг хэрхэн өөрчлөн шинэчлэх талаар захидалдаа үг, өгүүлбэр бичээгүй бөгөөд харин Сталин өөрийн дотоодын таагүй байдлыг гэтлэн туулахын тулд 1934 онд М.Горькийн нэр хүндийг ашиглан социалист реализмыг сөргүүлэн тавьсан билээ. Иймэрхүү гадаад дотоод нөхцөл байдлын нөлөөгөөр социалист реализм монголын уран зохиолд 1940-өөд оны сүүл үеэс эхлэн гол арга чиглэл болон ялгарч МАХН-ын олон жилийн шургуу тэмцэл, дэмжлэгт хэт зүүний үзэлт зохиолчдын ялалтаар өндөрлөсөн юм.

Энэ нь эцсийн дүндээ 1930-аад оны дунд үе хүртэл зөвлөлтийн уран зохиолын "түрэмгийлэл" маш бага байсан бөгөөд харин Марксист-Ленинист ул төр үзэл суртлын нөлөөлөл нь бүр хувьсгалын эхний жилүүдээс МАХН-ын нийгэм-улс төрийн одлогод нөлөөлж улмаар тэр нь шинэ уран зохиолыг удирдах үндэс суурь нь болж боловсорч байсан дүр зураг тодорхой харагдаж байна. 1948 оны Монголын зохиолчдын анхдугаар их хурлаар "хувьсгалт реализм"-ын улс төр-үзэл суртлын зарчим шалгууруудыг тодорхойлж "агуу их большевик намаас утга зохиол урлагийн тухай гаргасан шийдвэр, Зөвлөлтийн зохиолчдын баялаг туршлагаар биеээ зэвсэглэнэ гэдгээ ... нийгэм журамт их гүрний зохиолчдод батлан илэрхийлье" /12.5/ гэсэн долгомцог үгтэй цахилгаан утсыг ЗСБНХУ-ын Зохиолчдын эвлэлд илгээсэн нь нэг ёсондоо социалист реализмын анхдугаар түүхэн ялалтын илэрхийлэл байжээ. Удалгүй 1957 онд Монголын зохиолчдын эвлэлийн 2-р их хурлаар

"социалист реализм"-ын арга /16/ Монголын уран зохиолын гол арга гэж тодорхойлсон билээ.

Дэлхийн 2-р дайнаас хойш 1990-ээд оныг хүртэл Монголын уран зохиол Зөвлөлтийн уран зохиолын маш хүчтэй нөлөөлөлд хөгжсөн бөгөөд харин бусад социалист орнуудын уран зохиолыг зөвлөлтийнхтэй харьцуулахад нөлөөлөх бололцоо нь хязгаарлагдмал шинжтэй байсныг манай уран зохиолын түүх, орчуулгын уран зохиол, бүх шатны сургуулийн сургалтын төлбөрөөс тодорхой харагддаг. Монголын уран зохиолд социалист реализмын арга хөгжин боловсроход М.Горькийн захидал-зөвлөлгөөний оруулсан хувь нэмэр гэгч үлгэр иймэрхүү дүр төрхтэй юм.

Иймд дараах дүгнэлтүүдийг хийж болно.

1. 1925 онд Эрдэнэбатхаанд ирүүлсэн М.Горькийн захидалд дурдагдсан "идэвхтэй зарчим" гэдэг нэр томъёог социалист реализмын арга гэдэг утгаар тайлбарлах бололцоогүй. Учир нь энэ үед социалист реализмын тухай ойлголт дэлхийн урлаг ба уг онолыг үндэслэгч М.Горький санаанд ч төрөөгүй байсан бөгөөд бүр хожуу 1934 онд В.И.Сталины шууд оролцоотой, түүний томъёолсноор пролетарийн уран зохиол шилдэг сайн аргатай байх ёстой, "Тийм арга нь социалист реализм байх болно" /14.5-6/ гэсэн тулгалтаар энэ аргын улс төр, үзэл суртлын гол гол зарчмууд эхлэн тавигджээ.
2. 1920-30-аад оны сүүл үе хүртэл монголын уран зохиолд ямар нэг реализм цэвэр реализм бус харин нийт дорно дахины уран зохиолын хэв төрх, дэг найруулгад захирагдмал уламжлалт хуулбарлах, хийсвэрлэх, загварчлах /үлгэрчлэх/, бэлгэдэх, хэлбэрдэх, бодитчилох, бадрангуйн болон декандс арга найруулгыг хослон нийлэг аргатай байсныг мөн үеийн уран зохиолын дурсгалууд баталж байна.
3. 1920-30-аад оны эхэн үе гэхэд Монголын урлаг, утга зохиолд Хятад, Энэтхэг, Төвдийн уран зохиолын хуучин уламжлалт арга найруулгын нөлөө хүчтэй хэвээрээ байж, европ тэр дундаа Оросын уран зохиолын орчуулга, шууд оролцоо нөлөө, үндсэндээ хязгаарлагдмал байсан нь монголын орчин үеийн уран зохиолын түүхээс тодорхой юм. Энэ үед Оросууд өөр үндэстний уран зохиолд зөвлөлгөө өгөх бүү дотоодынхоо модернист хөдөлгөөний учрыг олохгүй сандарцгааж байжээ.
4. 1920-1930-аад он монголчуудын хувьд нийгмийн шилжилтийн эгзэгтэй үе байсан учраас шинэ тутам үүсгэн явуулсан орчин цагийн уран зохиол нь аман зохиол сүнстэй, хувьсгалт агуулга /М.Горькийн захидлын агуулгатай дүйх Д.Г/ бүхий чөлөөт уран сэтгэмжийн аргад үндэслэж байгаад үндсэндээ 1940-50-иад оноос социалист реализмын арга руу шилжиж эхэлжээ.
5. М.Горький пролетарийн хувьсгалын удирдагчидтай үе үе үзэл бодол зөрөх болж эмчлүүлэх нэрээр Италид очоод байсан цаг тул монголын сэхээтнүүдэд ямар нэг шалгарсан арга замыг заан зөвлөх, санал болгох бололцоогүй байжээ. Тэрээр монголчуудын уламжлалт аж ахуй, соёл урлаг, ёс заншлыг сайн мэдэхгүйн дээр биеийн байдал болоод Оросын уран зохиол дахь хямрал, социалист реализм онолын хувьд бэлтгэгдээгүй байсан зэрэг нөхцөл байдлууд нь түүнд Монголын сэхээтнүүдэд орчуулгын уран зохиол, "хувьсгалт" болон "социалист

реализм" талаар алсаас захидлаар "лекц унших" боломж байгаагүйг эгэл даруу үгтэй, товч нөхөрсөг зөвлөлгөө харуулдаг юм.

6. Монголын уран зохиол дахь социалист реализмын хөгжлийн асуудлыг М.Горькийн хувийн захидлаас улбаалан гаргаж тайлбарлах нь хэт гэнэн байр суурь бөгөөд харин түүнийг бие даасан арга болохынх нь хувьд 1. системийн мөн чанараар нь, 1. тухайн үндэстний нийгмийн байгуулал, хөгжлийн түвшин, нийгэм-улс төрийн түүх, гүн ухаан, ертөнцийг үзэх үзлийн сонголттой холбон урлаг, гоо зүйн мөн чанарынх нь үүднээс улс төр, үзэл суртлын холбоо, гадаад дотоод хүчин зүйлтэй нь цогц байдлаар авч үзэх шаардлагатай юм.

7. Монголын социалист реализмын уран зохиолын арга ба түүний хөгжилд оруулсан М.Горькийн хувь нэмэр, зөвлөлгөө гэх дээрх товч хариу захидал тухайн үедээ зохиолч бүрийн уншиж судласан /1930-аад оны эхээр анх хэвлэлд нийтлэгджээ. Д.Г/, тийм ч чухал зүйл байгаагүй бөгөөд бүр хожуу 1940-60-оны үед соц реализмын үүслийн "цэгийг" олж тогтоохыг эрмэлзсэн монгол судлагчдын эрлийн төгсгөл М.Горькийн захидалд буй "идэвхтэй зарчим" хэмээх ерийн үгэнд тулж очоод аажимдаа шидийг олж энэхүү үлгэр домгийн чанартай төөрөгдөл рүү хөтөлжээ гэж болмоор байна.

8. Монголын уран зохиол явгуураасаа дорны утга зохиолын ай савд хамаарагдаж, дорны билгийг ёсны уран зохиолын нийлэг арга зарчмаар хөгжиж ирсэн түүхтэй бөгөөд түүний хөгжлийн замналыг өрнө дахины уран зохиол лугаа тодорхой үе шат, урсгал чиглэлээр ялган зааглаж судлах бололцоогүй юм. Харин Дэлхийн 2-р дайны дараагаас монголд импортлогдсон "социалист реализм"-ын арга нь "зорилго нь аргаа зөвтгөнө" /14.5/ гэсэн Оросын аргын ёсны уран зохиолын зарчим руу шилжин орсныг 1990-ээд он хүртэлх уран зохиолын туурвил зүй харуулдаг юм.

НОМ ЗҮЙ.

1. Монголын орчин үеийн уран зохиолын товч түүх. УБ. 1968.
2. Монголын орчин үеийн уран зохиолын түүх. I боть. УБ. 1985.
3. Ц.Хасбаатар. Реализмын тухай. УБ. 1979.
4. П.Хорлоо. Аман зохиол ба монгол уран зохиол. УБ. 1975
5. Вопросы литературы. М. 1970. №6.
6. Найдаков. В Традиций и новаторства в Бурятской советской литературы. Улаан-Удэ. 1976.
7. Ц.Хасбаатар. Хувьсгалт реализм. Реализмын тухай ном. УБ. 1979.
8. Монголын уран зохиолын дээжис. /108 боть/ 42-р боть. УБ. 1998.
9. Идэвхтэй зарчим. УБ. УХГ. 1975.
10. Монголын уран зохиолын аргын судалгаа. УННС. док.дисс. УБ. 1999.
11. Qubisgal-un uranjokiyal. Ulaanbaatar. 1932. №1.
12. МЗЭ-ийн анхдугаар их хурал. УБ. 1948.
13. МАН-ын хоёрдугаар их хурлын тогтоол. УБ. 1923. /хуучин үсгээр/
14. Түмнээс нуух гэсэн бичиг баримт. /МҮЧЗХ-ны анхдугаар хурилдайны илтгэл/УБ. 1990.
15. Д.Норов. Үзэг нэгт нөхдөө дурсахуй. "Өнөөдөр" сонин. 1999. №169.
16. МЗЭ-ийн 2-р их хурал. УБ. 1957.
17. Письмо Горького Батхану-Эрдэни. Улан-Уде. 1925.5.19.